



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 2/09

Улаанбаатар хот

Монголын Оюутны спортын их наадмын Нийслэлийн бүсийн волейболын тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33,5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь заалт Засгийн газрын 2016 оны 158 тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн 2017 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/144 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Оюутны спортын их наадмын Нийслэлийн бүсийн волейболын тэмцээнийг 2017 оны 03 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны зааланд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 3.392.000 /гурван сая гурван зуун ерөн хоёр мянган/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын нөөц сангийн Монголын оюутны спортын их наадмын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнийг урьдчилан бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ж.ГАНБОЛД

1150500028

oytni ih naadam.docx

Нийслэлийн Нийслэлийн биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны 03 дүгээр сарын 07 ны өдрийн
1/09 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




Монголын Оюутны спортын их наадмын Нийслэлийн бүсийн
волейболын тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 24 хүн x 20.000 ₮ = 480.000 2-р байр 24 хүн x 15.000 ₮ = 360.000 3-р байр 24 хүн x 10.000 ₮ = 240.000	1.080.000 төг
2.	Шүүгчдийн ажлын зардал: /10 хүн x 2 өдөр x 50.000₮/	1.000.000 төг
3.	Заал талбайн түрээсийн зардал	900.000 төг
4.	Тээврийн зардал	100.000 төг
5.	Үзель, чимэглэл	150.000 төг
6.	Батламж	108.000 төг
5.	Анонс	54.000 төг
	Дүн	3.392 .000төг

Боловсруулсан:  С.Саранцэцэг

Хянасан:  О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны03..... дүгээр сарын 07 ны өдрийн
Мого дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Монголын Оюутны спортын их наадмын Нийслэлийн бүсийн
волейболын тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | Э.Мөнхдэлгэр |
| 2. Нарийн бичиг шүүгч | Л.Нацагдорж |
| 3. Шүүгч | Н.Батбаатар |
| 4. Шүүгч | Ё.Энхтайван |
| 5. Шүүгч | Г.Болд |
| 6. Шүүгч | Б.Цэрэндолгор |
| 7. Шүүгч | Б.Баясгалан |
| 8. Шүүгч | Ш.Мөнх-Эрдэнэ |
| 9. Шүүгч | С.Отгонбаатар |
| 10. Шүүгч | Б.Батсайхан |